ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/38 Бэрх хот

Дэмжлэг үзүүлж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архангай аймагт зохиогдох Үндэсний Параволейболын цомын аварга шалгаруулах "Архангай 2025-Хамтын хүч" тэмцээнд оролцох Л.Серёжад дэмжлэг үзүүлж 150,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 150,000 /нэг зуун тавин мянга/-н төгрөгийг Захирагчийн нөөц сангаас холбогдох хууль, дүрэм журмын дагуу гарган зарцуулахыг Захирагчийн ажлын албаны Нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАГЧ Ч.ЭНХЖАВХЛАН

•2325010038

БАТЛАВ
Архангай аймгийн биеийн
тамир, спортын газрын дарга
Г.Батболд

БАТЛАВ
Монголын параволейболын
холбооны тэргүүн
Х.Баясгалан

## ҮНДЭСНИЙ ПАРАВОЛЕЙБОЛЫН ЦОМЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ "АРХАНГАЙ 2025-ХАМТЫН ХҮЧ" ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2025.05.24

Эрдэнэбулган сум

Энэхүү тэмцээнийг зохион байгуулах үндсэн зорилго нь Монгол Улсын **"Биеийн тамир, спортын тухай"** хуулийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд "**ПАРАВОЛЕЙБОЛ**"-ын спортыг сурталчлан хөгжүүлэх, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн тамир, спортын арга хэмжээнд идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, багаар ажиллах чадварыг төлөвшүүлэх, орон нутаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мөн өндөр ур чадвартай тамирчдыг илрүүлэн, улсын шигшээ баг сонгон шалгаруулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын холбоо

Архангай аймгийн ЗДТГазар, Архангай аймгийн БТСГазар, МПВХолбоо, ХБИХЗөвлөл

Чингис хаан групп, Нутаг хүнс ХХК, Газрын гагнаас ХХК

Тэмцээн нь олон улсын "ПАРАВОЛЕЙБОЛЫН ХОЛБОО"-ны дүрмийн дагуу явагдана. Тэмцээнийг шударга, хариуцлагатайгаар явуулах үүрэг бүхий шүүгчдийн бүрэлдэхүүнийг зохион байгуулах ажлын хэсгээс томилно. Тэмцээнд оролцох баг тамирчид зориулалтын өмсгөл, номер, тоглолтын ижил хувцас болон хамгаалалтыг хэрэглэж оролцоно.

Архангай аймгийн "ARA ARENA" спортын ордонд 2025 оны 7 сарын 03 өдөр зохион байгуулагдана.

Загварын дагуу харьяалагдах спорт хороогоор баталгаажуулсан багийн мэдүүлгийг хаягт 2025 оны 06 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл хүлээн авна. Заасан хугацаанд мэдүүлэг ирүүлээгүй тохиолдолд тухайн багийг оролцуулахгүй. анхаарна уу

Архангай аймгийн "ARA complex" цагаан асарт 2025 оны 07 дугаар сарын 02 өдрийн 20:00 цагт хийж, тамирчдын мандатыг олгоно.

МПВХ-ны үнэмлэх, Иргэний үнэмлэх, 1 хувь зураг

Тэмцээнд оролцож буй эрэгтэй болон эмэгтэй баг, тамирчдын мандатын хураамж нь тус бүр 100,000 (нэг зуун мянган) төгрөг байна. Мандатын

төлбөрийг бүртгэлд орсон бүх оролцогч баг төлөх бөгөөд төлбөр нь тэмцээний зохион байгуулалтад зарцуулагдана

2025 оны 07 дугаар сарын 03 өдрийн 13:00 цагт "ARA complex" эхлэх ба багийн ахлагч тамирчдаа бүрэн хамруулах үүрэг хүлээнэ

Аймаг дүүргийн спорт хороод тэмцээнд баг тамирчдаа оролцуулахад шаардагдах дараах зардлыг хариуцна

- ✓ Тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл, байр, хоолны зардал
- ✓ Бэлтгэлийн болон тоглолтын хувцас хэрэгслийн зардал
- ✓ Тээвэр, шатахууны зардал
- ✓ Хагдвар хамгаалал, эмнэлгийн харалтай анхны тусламж үйлчилгээний зардал

- ✓ Тамирчид оршин суугаа харьяаллын дагуу тухайн тэмцээнд оролцоно
- ✓ Эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 7 тамирчин, 1 дасгалжуулагчтай байна
- ✓ Тэмцээнд нуруу нугас, тархины гэмтэл болон харааны бэрхшээлтэй тамирчдыг оролцуулахгүй
- ✓ Багийн дасгалжуулагч нар тамирчдын эрүүл мэндийн асуудлыг бүрэн хариуцна

Тэмцээнд оролцогч баг тамирчид нь багийн эмблемтэй футболк, биеийн тамирын хувцастай нээлтийн ажиллагаанд оролцоно

Тэмцээнд оролцож байгаа баг тамирчид дүрмийн бус үйлдэл гаргахыг цээрлэх ба спортын цэвэр шударга өрсөлдөөнийг эрхэмлэнэ

- ✓ 1-р байр: Өргөмжлөл, алтан медаль, үнэ бүхий зүйл
- ✓ 2-р байр: Өргөмжлөл, мөнгөн медаль, үнэ бүхий зүйл
- ✓ 3-р байр: Өргөмжлөл, хүрэл медаль, үнэ бүхий зүйл
- ✓ Багийн дүн: Цом, өргөмжлөл, мөнгөн шагнал

94113277, 94113603

**БОЛОВСРУУЛСАН:**

Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын Зөвлөлийн тэргүүн /          / Г.Самбуудандан

Хэнтий аймаг
Бэрх хотын
ЗДТГазар. дарга Ч. Энхжавхлан
танд өргөдөл гаргах нь:

2025оны 06.30нд.

Л. Серёжа миний бие нь Бэрх хотынхоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ төлөөлөн „Архангай" аймагт зохион байгуулагдах „Үндэсний пара волейболын" цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцох шаардлагатай байгаа тул тэмцээнд хэрэглэгдэх замын зардал бусад хэрэгцээний зардлыг гаргаж өгнө үү.

Л. Серёжа.

Утас: 99967538

Данс 5954316264